

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дашзэвэг	Дугаар	L171
Оршин суугаа аймаг	Сэлэнгэ	Оршин суугаа сум	Ерөө
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Цагаан тохойн дуган, Далангийн дуган	Сүм хийдийн дугаар	СЭОТ 062, СЭЕР 034
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 18	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан

Сэлэнгэ аймгийн Орхонтүүл сумын Цагаан тохойн буюу Дарь эхийн хурал, Ерөө сумын Далангийн дуган 2007 оны 7 сарын 18-ны өдөр. Судалгааны баг Сэлэнгэ аймгийн Бугант тосгоны өндөр настан, Монгол улсын хөдөлмөрийн баатар Дашзэвэг гуайтай уулзаад байна.

Асуулт:-Ингээд Дашзэвэг гуайгаас бид нар тус сумын нутагт байсан Цагаан тохойн, Далангийн дуганы тухай, **Ходоодын** хурал хоёрын тухай яриулах гэж байна. Та бидэнд ярьж өгнө үү.

Хариулт:- Манай аавын ах лам тэр Далангийн дуганыг толгойлж байсан Чойдог гэж лам байсан. Ингээд 37 оны 10-р сард юмуу баригдаад эргэж ирээгүй л дээ. Тэр чигээрээ дууссан. Тэр Далангийн дуган бол нэлээн олон лам нартай 70-аад лам хурдаг ийм дуган байсан юм байна лээ л дээ. Тэгээд өвгөнийг ирж 37 онд юмыг нь тэр үед лацдах гэж байсан юм даа. Нэг шөнө ирээд манайд миний дээд талын ах тэнд гал тогоо юмыг нь барьдаг байсан юм, тэр Чойдог ах ламын. Шөнө ирээд ерөөсөө өөрийг нь ч хөдөлгөхгүй, бүх юмыг нь тоолоод тэгээд лацдаад энэ хөдөлгөж болохгүй гээд ингээд явчихсан юм байна лээ, тэгээд өөрийг нь барьж аваад. Өөрийг нь хааш нь хөдөлгөхгүй байж байгаад бүх юмыг нь **тооцож** аваад ингээд лацдаад сүүлдээ тэр өвгөн ч **яхав** баригдаад явсан, сураггүй алга болсон л доо. Юмыг нь сүүлдээ эргэж тэр **тоологдсон** юмыг нь авсан юм гэнэ лээ. Алт мөнгө юу ч байдаг юм.

Манай Харзны дов гэдэг газар манай ээж, аав байж байсан. Ах ламыг бариад явчихсан гэсэн. Тэр бас нэг хэдэн мал байсан юм байна лээ, манай аав ээж харж байдаг. Тэрнийг нь бас сүүлдээ хурааж аваад явсан л даа. Тэр 10 гаран л юм байна лээ, сүүлдээ хэдийд ч эргэж ирсэн юм, нөгөө лацдаж ломбодсон юмаа авсан.

Асуулт:-70 гаруй ламтай байсан гэсэн. Бусад ламыг нь яасан юм бол?

Хариулт:-Бусад лам нэг их баригдаад байсан юм байхгүй, зарим нь ч хар болоод бариад **тавианы** үеэр явчихсан юм байна лээ. Далх лам гэж байсан тэр байж байгаад харин яагаагүй л гэсэн. Энэ Галсандагвын Балдан гэж нэг гавж байсан юм. Тэр баригдаад 10 жил хотын хориход байж байгаад сүүлд гарч ирсэн юм байна лээ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Дуган модоор баригдсан байсан уу?

Хариулт:-Модоор.

Асуулт:-Лам нарыг бариад явчихсан хойгуур дуган нь байж байсан уу?

Хариулт:-Дуганы бурхан тахилыг нь аваад заримыг нь голын, хойш нь Дашбалбар гэж уулын хярд тэнд аваачиж шатаасан юм байна лээ. Юмнуудыг нь аваад. Тэгж явахад манай хөгшчүүл айгаад ерөөсөө яаж ч чаддаггүй, дуганы юмыг нь ирээд авч байна уу, хураалаа гээд заримыг нь усанд ч юмуу хаясан юм шиг байна лээ, тэр хойно уулын өвөрт очиж шатаасан юм байна лээ.

Асуулт:-Дуганы модыг яасан юм бол?

Хариулт:-Мод гээд байх юм ч мэдэхгүй, зүгээр **нэг сургааган хашаа** байсан, тэрнийг нь хуучин Хар Жадамба гэж байсан юм, тэд аваад яасан юм шиг байна лээ. Барилга гээд хурааж аваад байх юм байхгүй.

Асуулт:-Дуганыг бүрэн бүтэн байхад нь та харж байсан уу? **Хэр том** дуган байсан юм бол?

Хариулт:-Бага байлаа л даа, би 8,9 настай байсан. Майдар эргэх гээд нэг яасан юм. Зүүн, Баруун хүрээ гэж байх ёстой юм, тэгээд Майдар, **Майдарын** ногоон морь дээрээ нар **зөв тойрох** юм, тэгээд хэнгэрэг цан юм болсон их л гоё юм болдог юм байна л даа. Тэгэхийг нь нэг үзсэн юм.

Асуулт:-Майдар жилд нэг удаа эргэдэг байсан уу?

Хариулт:-Жилд нэг удаа эргэдэг юм шиг байгаа юм.

Асуулт:-Аль улиралд нь эргэдэг байсан юм бол?

Хариулт:-Зуны хэдэн сард юм.

Асуулт:-Майдарынхаа багийг өөрсдөө хийдэг байсан уу?

Хариулт:-Өөрсдөө дуганд яагаад ногоон морь, морины цээж тавьчихсан байх юм, нэг их лам дэргэд нь суучихсан байх юм, 4 дугуйтай тэргэн дээр нар зөв гараад дуганаа тойруулаад ингээд хэнгэрэг цан болсон, урт бүрэнүүд үлээгээд. 2 хүн мөрөн дээгүүрээ дамначихсан байдаг.

Асуулт:-Тэр дуганы лам нар ямар уул овоогоо тахидаг байсан юм бол?

Хариулт:-Их овоо гэж Баянголын гүүр байна, Гүүрний цаад талд хувхай түймэрт шатчихаад байхгүй болчихсон л доо, эндээс Их овоо, хойш Дашбалбар, дор Хоёр овоо гэж цаана хоёр талд нь хоёр чулуу **яачихсан**, хоёр овоо гээд. Овоонууд тахидаг юм байна лээ.

Асуулт:-Хавар тахидаг байсан уу?

Хариулт:-Зун. Сайхан цагаар тахидаг байсан юм. Шүүс, хонь мал яагаад, цагаан идээ юугаа ч байдаг юм аваад тэгээд л энд тэнд **наадамархуу** юм болдог юм байна л даа. Би бага байсан болоод бүүр түүр мэдэхгүй байгаа юм.

Асуулт:-**Жод лүйжин** тавьдаг байсан юм болов уу?

Хариулт:-Тэрнийг сайн мэдэхгүй. Өөрөө бага байсан, олон жил болсон, сайн мэдэхгүй. Чойдог лам гэдэг байсан Далангийн дуганы их лам нь байсан л даа, манай аавын ах нь. Нэг шөнө ирээд л миний дээд талын ах бичиг заалгаад гадуур байдаг. Өөрийг нь ч хөдөлгөхгүй, бүх юмыг нь тоолоод лацдаад ... 10-аад үхэр байсан юм

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байна лээ, манай дээр байдаг байсан юм. Тэрнийг сүүлд тоолж аваад туугаад явсан гэдэг. Ээж **маань ингэж** ярьж байсан юм. Хотыг маань харлууллаа даа, **хүү чинь** гэж үйлж байсан юм гэнэ лээ, малыг нь хураагаад аваад явахад. Манайх тийм их мал байхгүй, саадаг үнээ, унах мориноос өөр юм байхгүй байсан л даа.